Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн
101 дүгээр тушаалын 11 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга 2023-07-07 |
| Дагаж мөрдөх огноо: | 2024-01-01 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | 2024-06-12 |
| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | Хяналт шалгалтын газар |
| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл |
| Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч | Дэс түшмэл, ТЗ-6 |
| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил: |
| Ажлын өдрийн 8 цаг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу 13/1 |
| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Нийгмийн халамжийн багц хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг Хяналт шалгалтын газрын даргын өмнө хариуцна.

3024020135 СТС4666 9081739

Төрийн албаны зөвлөлийн
2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн
208 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга 2023-07-07 |
| Дагаж мөрдөх огноо: | 2024-01-01 |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | Хяналт шалгалтын газар |
| **Албан тушаалын нэр:** | **Албан тушаалын ангилал, зэрэглэл** |
| Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч | Дэс түшмэл, ТЗ-6 |
| **Ажлын цаг** | **Ажлын байрны албан ёсны байршил:** |
| Ажлын өдрийн 8 цаг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу 13/1 |
| **Хөдөлмөрийн нөхцөл:** | **Онцгой нөхцөл:** |
| Хэвийн | Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

**Албан тушаалын зорилго:**

Нийгмийн халамжийн багц хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг Хяналт шалгалтын газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй хууль тогтоомж, бодлого, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

2.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан Улсын ахлах байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх;

3.Нийслэл,орон нутгийн нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

4.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх;

5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр хяналт шалгалтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, тайлагнах; | Хяналт шалгалтын бодлого, төлөвлөлт хэрэгжсэн байна. | Г, Х, Ш |
| | 2.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, салбарын эрх зүйн орчин боловсронгуй болгох, шийдвэрлүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулж зохих байгууллагад хүргүүлэх; | Хяналт шалгалтын үр дүн дээшилж, эрх зүйн орчин сайжирсан байна. | Г |
| | 3.Эрсдэлийн шалгуур үзүүлэлт боловсруулах, боловсронгуй болгох санал өгөх, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын мэдээллийг хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, улсын байцаагч нарын хийсэн хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээг хянах; | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Г |
| | 4.Хяналт шалгалтад ашиглах хяналтын хуудас болон хяналтын хуудсыг хэрэглэх зөвлөмжийг шинээр болон шинэчлэх саналыг нэгтгэн танилцуулах; | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Г |
| | 5.Нийслэл, орон нутгийн улсын байцаагчийн хяналт шалгалтын баримт бичиг, хянах, зохих стандартыг мөрдүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгөх. | Стандартын шаардлага хангасан байна. | Г, Х |
| | 1.Нийгмийн халамжийн багц хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | Г, Х |
| | 2.Нийгмийн халамжийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | Г, Х |

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Нийгмийн халамжийн сангаас олгож буй бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн тогтоолт, олголтод хяналт тавих; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | Г, Х |
| | 4.Ахмад настны болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрамжилж буй асрамжийн газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж үнэлэлт, дүгнэлт өгөх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 5.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэжээн тэтгэгчгүй хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдийг асрамжилж буй хүүхдийн асрамжийн газар, төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 6.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай Асрамжийн газруудад төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 7.Ахмад настны болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлдэг амралт, сувиллын газруудын үйл ажиллагаанд хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 8.Иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэхээр гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 9.Нийгмийн хамгааллын болон өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааны чадавхыг дэмжих, ядуурлыг бууруулахтай холбогдолтой арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулагдсан төсөл, зээл, тусламж, хандивын хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 10.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 11.Нийгмийн даатгалын сангуудын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих; | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | Г, Х |
| | 12.Нийгмийн даатгалын сангаас болон улсын төсвөөс олгож буй бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын тогтоолт, олголтод хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 13.Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд хяналт тавих; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 14.Эрүүл мэндийн байгууллагуудаас даатгуулагчдад олгож буй жирэмсэн болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |

| | | | |
|---|---|---|---|
| | бичилт, үндэслэлд хяналт тавих; | | |
| | 15.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 16.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж улсын орлого болгох, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 17.Улсын ахлах байцаагчийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд түүнийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх, эсхүл тухайн ажил, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх; | Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна. | Г, Х |
| | 18.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хянан үзэж, шийдвэрлэх. | Хуулийн хугацаанд үнэн зөв шийдвэрлэсэн байна. | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Нийслэл, орон нутгийн нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд тулгуурлан саналаа танилцуулах; | Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын чадавх дээшилнэ. | Г |
| | 2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу болон бусад арга хэлбэрээр улсын байцаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах; | Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын чадавх дээшилнэ. | Г |
| | 3.Байгууллагын болон салбарын сургалт зохион байгуулах удирдамж, төлөвлөлт, арга зүй, хөтөлбөр, гарын авлага, зөвлөмж, мэдээллээр хангаж, үр дүнг тооцох. | Улсын байцаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын чадавх дээшилнэ. | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Хуулиар харьяалуулсан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоосон хугацаанд явуулах; | Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын дагуу явуулсан байна. | Г, Х |
| | 2. Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, зөрчлийн үр дагаврыг арилгаагүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах; | Зөрчил дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлсэн байна. | Г, Х |
| | 3. Хуульд заасан үндэслэл, журмын | Зөрчлийн үр дагавар | Г, Ш |

МОНГОЛ ... ЗӨВЛӨЛ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | дагуу эрх хязгаарлах арга хэмжээг авах саналыг прокурорт хүргүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах. | арилж, хохирол нөхөн төлбөр төлөгдсөн байна. | |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг тооцуулах; | Хэрэгжилтийг хангаж тайлагнасан байна. | Г |
| | 2.Бодлогын баримт бичигт тусгагдсан тухайн хяналтын чиглэлд хамааралтай зорилт, арга хэмжээний биелэлтийг орон нутгийн нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчдаас гаргуулан авч нэгтгэх, танилцуулах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх; | Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна | Г |
| | 3.Шаардлагатай асуудлаар ажлын хэсэг, комиссын бүрэлдэхүүнд ажиллах; | Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна | Г |
| | 4.Нийслэл, орон нутгийн нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчдын хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, шийдвэрлэх; | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | Г |
| | 5. Байгууллагын дотоодод мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох; | Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна. | Г |
| | 6.Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах; | Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна. | Г |
| | 7.Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журмын дагуу хэрэгжүүлэх; | Заавар, журам, стандартад нийцсэн байна. | Г |
| | 8.Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх. | Шаардлагын түвшинд хэрэгжүүлсэн байна. | Г |

| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | |
|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. |
| Мэргэжил | -эдийн засаг /0311/;<br>-нягтлан бодох бүртгэл, татвар /0411/; |

МОНГОЛ УЛС ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ЗОВИНООРОВ

| | | |
|---|---|---|
| | -санхүү, банк, даатгал /0412/;<br>-менежмент ба удирдахуй /0413/;<br>-эрх зүй /0421/. | |
| Мэргэшил | Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчийн эрхтэй байх. | |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | |
| Ур чадвар | Дүн шинжилгээ хийх | - Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;<br>- Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;<br>- Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй;<br>- Мэдээллийн уялдаа холбоо, чиг хандлагыг олж харж чаддаг байх;<br>- Хяналтын объектуудад эрсдэлийн үнэлгээний дүнг нэгтгэж, харьцуулсан судалгаа гаргах;<br>- Хариуцсан хяналтын салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;<br>- Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;<br>- Хариуцсан хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэж, харьцуулсан судалгаа гаргах;<br>- Бодлогын баримт бичигт үндэслэлтэй санал боловсруулах;<br>- Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;<br>- Бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;<br>- Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах;<br>- Хяналт шалгалтын мэдээллийн сангийн үнэн, бодит байдлыг шалгах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;<br>- Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж түүний эерэг ба сөрөг үр дагаврын талаар судлах, удирдлагад танилцуулах;<br>- Илэрсэн зөрчил, дутагдалд албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах;<br>- Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж, шийдвэрийн төсөлд тусгах;<br>- Гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах;<br>- Бусад. |
| | Багаар ажиллах | - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;<br>- Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- Бусдын санал бодлыг анхааралтай сонсож оновчтой санал санаачилгыг дэмжиж ажиллах;<br>- Асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх;<br>- Сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг хэлэлцэх;<br>- Багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;<br>- Бусад. |
| | Бусад | - Төрийн албан хаагчийн болон Нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авилга, ашиг |

| | | |
|---|---|---|
| | | сонирхлын зөрчлөөс ангид байх;<br>- эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- Гадаад хэл, мэдээллийн технологийн болон бусад зайлшгүй шаардлагатай ур чадвар;<br>- Мэдээллийн технологийг албан ажилдаа бүтээлчээр хэрэглэх;<br>- Кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх. |

**IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Хяналт шалгалтын газрын дарга

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
|---|---|
| Төв болон орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагад ажиллаж буй Нийгмийн хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагч | 1.Яам, агентлаг, тэдгээрийн газар, хэлтсийн холбогдох албан тушаалтан;<br>2.Төрийн бусад байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн холбогдох ажилтан;<br>3.Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага. |

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br>БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА<br>........................................ Ц.ГАНЦЭЦЭГ<br>(Гарын үсэг)(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br><br>2024 оны 05 сарын 24-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br><br>Шийдвэрийн огноо: 24 0524<br>Дугаар: 208 |

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

Байгууллагын нэр:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2024.06.12
Дугаар: А/101
(тамга/тэмдэг)
ДАРГА...................................... Л.МӨНХЗУЛ
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ